

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

НЭГ. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүл мэндийн тухай хууль нь 2011 онд батлагдсанаас хойш нийт 31 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсны улмаас зохицуулалтын уялдаа холбоо алдагдаж, салбарын хөгжлийг цогцоор нь чиглүүлэх системийн шинж чанар сул болсон байна. Үүний улмаас эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалт, хэрэгжилт хоорондын уялдаа хангалтгүй болж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдээд байна.

Монгол Улсын Үндсэн хуульд иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг баталгаажуулсан бөгөөд төр уг эрхийг хангах үүрэгтэй. Мөн “Алсын хараа–2050” урт хугацааны хөгжлийн бодлогод нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, дижитал эрүүл мэндийн хөгжлийг эрчимжүүлэх зорилтыг дэвшүүлсэн нь салбарын эрх зүйн орчныг шинэчлэх бодит шаардлагыг бий болгож байна.

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн тогтолцоонд дараах суурь хүндрэлүүд байна. Үүнд: нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм зүйн тусламж үйлчилгээ хоорондын уялдаа сул; эмнэлэг төвтэй загвар давамгайлж, урьдчилан сэргийлэх бодлого хангалтгүй; санхүүжилтийн тогтолцоо тогтворгүй, иргэдийн халааснаас гарах зардал өндөр; эрүүл мэндийн даатгалын сангийн алдагдал нэмэгдсэн; төрийн өмчит эмнэлгүүдийн засаглал, төлөөлөн удирдах зөвлөлийн хэрэгжилт хангалтгүй; хүний нөөцийн хомсдол, ялангуяа хөдөө орон нутгийн мэргэжилтний дутагдал нэмэгдсэн; эм зүйн салбар эмийн хангамж, худалдааны хүрээнд түлхүү зохицуулагдаж, тусламж үйлчилгээний нэг бүрэлдэхүүн хэсэг болж чадаагүй; дижитал эрүүл мэнд, телемедицин, мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

Иймд эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтыг хэсэгчилсэн байдлаар бус, тогтолцооны түвшинд шинэчлэн боловсронгуй болгох шаардлагатай байна. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь эрүүл мэндийн тогтолцоог “эмнэлэг төвтэй” загвараас “нийгмийн эрүүл мэнд төвтэй” тогтолцоо руу үе шаттайгаар шилжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих бодлогыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх суурь өөрчлөлтийг тусгасан.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг бодитой хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

Энэ хүрээнд эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалтыг салангид бус, харилцан уялдаа бүхий нэгдмэл тогтолцоонд оруулах, санхүүжилт, хүний нөөц, технологи, удирдлага, зохион байгуулалтын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдуулан зохицуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Хуулийн төсөл нь эрүүл мэндийн тогтолцооны бүтэц, удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм зүйн тусламж үйлчилгээ, санхүүжилт, эрүүл мэндийн даатгал, хүний нөөц, дижитал эрүүл мэнд, мэдээллийн нэгдсэн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээний харилцааг цогцоор нь зохицуулна.

Мөн төр, орон нутгийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн ажилтан, иргэн, даатгуулагч зэрэг оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага, харилцан уялдааг тодорхой болгож, салбарын ил тод байдал, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, БҮЛЭГ ТУС БҮРЭЭР ЗОХИЦУУЛСАН АГУУЛГА

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь нийт 9 бүлэг, 50 зүйлтэй.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, эрүүл мэндийн хууль тогтоомжийн бүрэлдэхүүн, нэр томъёоны тодорхойлолт, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндсэн зарчмыг тусгасан. Энэ бүлэгт хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлах, нийгмийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгох, эрүүл мэндийн байгууллагын бие даасан байдлыг хангах, салбар дундын оролцоог дэмжих зэрэг суурь зарчмыг хуульчилсан.

Хоёрдугаар бүлэгт эрүүл мэндийн тогтолцоог нэгдмэл систем гэж тодорхойлж, удирдлага, зохион байгуулалт, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн болон эм зүйн тусламж үйлчилгээ, хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, технологи, мэдээлэл, цахимжилт, санхүүжилт, даатгал зэрэг бүрэлдэхүүн хэсгийг харилцан уялдаатайгаар төлөвлөж, хэрэгжүүлж, үнэлэх шаардлагыг тусгасан. Мөн төр эрүүл мэндийн тогтолцооны тогтвортой, тасралтгүй ажиллагааг хангах, тогтолцооны аль нэг хэсгийг орхигдуулахгүй байх, эрсдэл, онцгой нөхцөл байдлын үед бэлэн байдлыг хангах үүрэгтэй байхаар зохицуулсан.

Гуравдугаар бүлэгт эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог тодорхойлсон. Эрүүл мэндийн удирдлагад Улсын Их Хурал, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, эм зүйн тусламж хариуцсан байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг хамруулсан. Ингэснээр бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, үнэлэх чиг үүргийг төв, орон нутаг, байгууллагын түвшинд уялдуулж, засаглалын давхардал, хийдлийг бууруулах нөхцөл бүрдэнэ.

Дөрөвдүгээр бүлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм зүйн тусламж үйлчилгээ гэсэн гурван үндсэн төрөлтэй байхаар тодорхойлсон. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх хүрээнд Ерөнхий сайдын дэргэд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл ажиллуулахаар тусгаж, салбар дундын хамтын ажиллагаа, оролцоонд тулгуурлан бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангахаар зохицуулсан.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хувьд анхан, хоёрдогч, гуравдагч шатлалын уялдаа холбоог хангаж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг суурь байгууллага гэж үзсэн. Мөн хүн амын хэрэгцээ, шаардлагад үндэслэн эмнэлгийн сүлжээ, хүчин чадал, үйлчилгээний төрөл, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, эрүүл мэндийн технологийн үнэлгээг хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрлийн шийдвэрийг мэргэжлийн дүгнэлтэд үндэслэн зохицуулалтыг тусгасан. Эм зүйн тусламж, үйлчилгээний хувьд эм, вакцин, эмнэлгийн хэрэгслийг зөвхөн худалдаа, ханган нийлүүлэлтийн бүтээгдэхүүн бус, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзсэн.

Тавдугаар бүлэгт эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог шинэ үзэл баримтлалаар тодорхойлсон. Санхүүжилт нь иргэнийг эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашиг, тогтвортой байдлыг хангах бодлогын хэрэгсэл байхаар тусгасан. Эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хандив, тусламж, төлбөртэй тусламж үйлчилгээний орлого болон бусад эх үүсвэрээс бүрдэхээр тодорхойлсон.

Мөн эрүүл мэндийн салбарын нийт санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас доошгүй хувьд хүргэх зорилт, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, анхан шатны тусламжийн санхүүжилт, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний эх үүсвэр, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн аргачлалыг тусгасан. Анхан шатны тусламжийг даатгалтай эсэхээс үл хамааран үнэ төлбөргүй үзүүлэх, хоёрдогч болон гуравдагч

шатлалын зарим нэн шаардлагатай тусламжийг улсын төсөв, даатгалын сангаас санхүүжүүлэхээр зохицуулсан.

Мөн эмийн үнийн хөнгөлөлт, дархлаажуулалтын эм, бэлдмэл, сүрьеэ, ХДХВ, гепатитын эмчилгээний эм, жирэмсэн эмэгтэй, хүүхдэд шаардлагатай амин дэм, эрхтэн шилжүүлэн суулгасны дараах эм, сэтгэцийн эмгэгийн урт хугацааны эмчилгээний эмийн санхүүжилтийг тодорхой эх үүсвэрээр шийдвэрлэхээр тусгасан. Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг төвлөрсөн байдлаар зохион байгуулж, чанар, аюулгүй байдал, үр нөлөө нь баталгаажсан ерөнхий нэршлийн эмийг тэгш нөхцөлөөр оролцуулах зохицуулалтыг тусгасан.

Зургаадугаар бүлэгт эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогыг урт хугацаанд төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх зохицуулалтыг тусгасан. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын хэмжээнд хүний нөөцийг зохистой байлгах нэгдсэн төлөвлөгөөг дөрвөн жилээр боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд уг төлөвлөгөөнд хүний нөөцийн эрэлт хэрэгцээ, бэлтгэл, давтан сургалт, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн баталгаа, дутагдалтай бүс нутагт хүний нөөцийг хуваарилах, тогтвортой ажиллуулах арга хэмжээг тусгана.

Долоодугаар бүлэгт дижитал эрүүл мэндийн бодлого болон эрүүл мэндийн мэдээллийн зохицуулалтыг тусгасан. Мобайл тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн мэдээллийн систем, теле-эрүүл мэнд, теле-медицин, хиймэл оюун зэрэг технологийг ашиглан тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэхээр зохицуулсан. Мөн эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журмыг тогтооно. Эрүүл мэндийн мэдээллийг үндсэндээ өвчтөний зөвшөөрөлд үндэслэн цуглуулах боловч амь насанд аюултай болон яаралтай тусламжийн нөхцөлд зөвшөөрөлгүйгээр цуглуулах боломжийг тодорхойлсон.

Наймдугаар бүлэгт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагын оролцоог тусгасан. Иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, өрхийн эмчээ сонгон бүртгүүлэх, өөрийн эрүүл мэндийн мэдээлэлтэй танилцах, мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах эрхтэй байхын зэрэгцээ эрүүл мэндийн боловсрол эзэмших, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах, халдварт өвчний дэглэм сахих, эрүүл мэндийн ажилтны үйл ажиллагаанд саад учруулахгүй байх үүрэгтэй. Аж ахуйн нэгж, байгууллага ажилтны эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах үүрэгтэй. Төрийн бус байгууллага олон нийтийн хяналт тавих, сургалт, сурталчилгаа зохион байгуулах зэргээр оролцоно.

Есдүгээр бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгасан.

ДӨРӨВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШЛАГА

Хуулийн төслийг боловсруулахдаа олон улсын байгууллагын зөвлөмж, бусад улсын туршлагыг харгалзан үзсэн. Тухайлбал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлсон эрүүл мэндийн тогтолцооны 6 блок буюу үйлчилгээ, хүний нөөц, мэдээллийн тогтолцоо, эм ба технологи, санхүүжилт, удирдлага-засаглалын загварыг харгалзан эрүүл мэндийн тогтолцоог нэгдмэл системийн хувьд зохицуулсан.

Санхүүжилтийн хувьд стратегийн худалдан авалт, нэг худалдан авагчийн тогтолцоо, тохиолдолд суурилсан төлбөр, үр дүн, чанарт суурилсан санхүүжилтийн олон улсын чиг хандлагыг тусгасан. Энэ нь эрүүл мэндийн санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх, илүүдэл зардлыг бууруулах, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой.

Дижитал эрүүл мэндийн хувьд БНХАУ болон Зүүн Өмнөд Азийн орнуудын телемедицин, теле-эрүүл мэнд, мэдээллийн нэгдсэн системийн туршлагыг харгалзан үзсэн. Нийгмийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгох бодлогын хувьд OECD-ийн орнуудын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх бодлогын чиг хандлагыг тусгасан.

ТАВ. ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН УЯЛДАА, ДАГАЛДАХ ӨӨРЧЛӨЛТ

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг хангах зорилготой бөгөөд холбогдох салбарын хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулагдсан.

Хуулийн төсөл батлагдсантай холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд эрүүл мэндийг дэмжих, хамгаалах арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тухайлбал эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх бүтээгдэхүүний онцгой албан татварын тодорхой хувийг нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд зарцуулах зохицуулалт тусгана.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд даатгалын шимтгэлийн хувь хэмжээг шинэчилсэн найруулгын санхүүжилтийн зохицуулалттай уялдуулах өөрчлөлт орно. Энэ нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын тогтвортой байдлыг хангах, стратегийн

худалдан авалтыг хэрэгжүүлэх, иргэдийг эрүүл мэндийн зардлаас хамгаалах бодлоготой уялдана.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөл, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, тусгай зөвшөөрөл, дотоод хяналт, магадлан итгэмжлэлтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгахаар байна. Дагалдах хуулийн төслүүд нь шинэчилсэн найруулгын үндсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх санхүүжилт, байгууллагын тогтолцоо, засаглал, чанарын хяналтын эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтыг хэсэгчилсэн байдлаар бус, тогтолцооны түвшинд цогцоор нь шинэчлэхэд чиглэсэн. Хуулийн төсөл батлагдсанаар иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах үндсэн эрхийг бодитой хэрэгжүүлэх эрх зүйн орчин сайжирч, эрүүл мэндийн тогтолцооны удирдлага, санхүүжилт, хүний нөөц, тусламж үйлчилгээ, эм зүй, дижитал эрүүл мэнд, мэдээллийн зохицуулалт харилцан уялдаатайгаар хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн эрүүл мэндийн тогтолцоог эмнэлэг төвтэй загвараас нийгмийн эрүүл мэнд төвтэй тогтолцоо руу шилжүүлэх, урьдчилан сэргийлэх бодлогыг тэргүүлэх чиглэл болгох, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийг оновчтой төлөвлөх, дижитал эрүүл мэндийг хөгжүүлэх, иргэн төвтэй, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх эрх зүйн суурь бүрдэнэ.

—оо00оо—